



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№224 /433/

2022.12.12

Цаг үе, үйл явдал

ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ КОМИСС АЖИЛЛАГААНЫ ГАЗАР ОРОНД...



Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын XI, XII ээлжийн мотобуудлагын батальонуудын ээлж хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар ахалж, арванхоёрдугаар сарын 2-ны өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад ажиллаж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

-Монгол Улсын XI ээлжийн мотобуудлагын батальоны үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны газар орны бодит байдалтай танилцах,
- НҮБ-ын "UNMISS" энхийг сахиулах ажиллагааны

уидрдала болон холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцох,
- Цэргийн багт шаардлагатай ажиллагааны газар орны зах зээлээс худалдан авах боломжтой бараа материалыг судлах, худалдааны байгууллагуудтай танилцах, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг худалдан авах гэрээ байгуулах,
- Цэргийн багийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн зохион байгуулахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх,
- Мотобуудлагын батальонуудын ээлж хүлээлцэх ажиллагааг зохион байгуулж, дараагийн ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхээр зорин ажиллаж байна.
Улмаар XII ээлжийн мотобуудлагын батальоноос

тус ажиллагааны шинэ байрлалд мотобуудлагын ротыг үүрэг гүйцэтгүүлэх болсонтой холбогдуулан ажлын хэсэг 12 дугаар сарын 06-ны өдөр секторын удирдлагатай уулзаж, мотобуудлагын ротын үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай асуудлаар харилцан санал солилцож, цэргийн алба хаагчдын ажиллах, үүрэг гүйцэтгэх орчин, нөхцөлтэй танилцаж үүрэг чиглэл өгчээ. Мөн Юнити секторын командлагч бригадын генерал Купер Майк Мужунитай ажлын уулзалт зохион байгуулж, секторын үйл ажиллагаатай танилцан, үүрэг гүйцэтгэлт, үер усны нөхцөл байдлын талаар мэдээлэл сонссон байна. Юнити мужид сүүлийн 60 жилд болоогүй үер усны гамшиг үргэлжлээд хоёр дахь жилдээ үер усны хүнд нөхцөлд энхийг сахиулах ажиллагаа явагдаж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-29


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.447	3.451
EUR	3.640	3.660
CNY	492	494
RUB	52	52.60
JPY	25.35	25.55
KRW	2.64	2.68

ЗУРХАЙ



2022.12.12 / ДАВАА ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ
ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

**Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.32-16.59**

Барилдлага:

**Үхэх
ШҮТЭН БАРИЛДАГА:
Хурьцахуй**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

МОНГОЛ УЛС "ЧИНГИС" БОНДЫН ӨРИЙГ БҮРЭН ТӨЛЖ БАРАГДУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ мэдээлэл хийлээ. Тэрбээр өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Сангийн сайдад "Чингис" бондын өрийн үлдэгдэл төлбөр болох 136 сая ам.долларын гүйлгээг шилжүүлэх эрх олгосон захирамжид гарын үсэг зурсан байна. "Ингэснээр Монгол Улс "Чингис" бондын 1.5 тэрбум ам.долларын өрийг бүрэн төлж барагдуулж байна" гэж Ерөнхий сайд хэллээ.

"Чингис" бондын 1.5 тэрбум ам.долларын хүүгийн төлбөрт 2012 оноос энэ оны зургадугаар сарын 5-ны хооронд нийт 542.9 сая ам.долларын төлбөрийг төлсөн байна. 2022 оны арванхоёрдугаар сард 3.4 сая ам.долларыг "Чингис" бондын сүүлийн хүүгийн төлбөрт төлж байна.

Мөн Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтөөр "Самурай" бондын 223 сая ам.долларын өрийг бүрэн төлөхөд бэлэн болсныг Ерөнхий сайд мэдэгдлээ.

**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 653,815,436

Эдгэрсэн

Нийт: 629,254,840

Нас барсан

Нийт: 6,658,727

Цаг үе, үйл явдал

АГААРЫН ЦЭРГИЙНХЭН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАЙЛАГНАЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын харьяа ангиудын тайлангийн хурлыг өнгөрөгч сарын 30-ны өдөр, Агаарын цэргийн командлалын тайлангийн хурлыг энэ сарын 7-ны өдөр тус тус зохион байгуулж, үйл ажиллагаагаа дүгнэн хэлэлцлээ.

Агаарын цэргийн командлалын тайлангийн хуралд ЗХЖШ-ын орлогч дарга, Цэргийн тагнуулын газрын дарга хошууч генерал А.Ганбат, ЗХЖШ-ын ХШҮГ-ын Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга хурандаа Х.Алтанцож нар оролцож, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцан зарим арга хэмжээний талаар нарийвчлан тодотгож, цаашид анхаарах асуудлуудаар зөвлөмж, чиглэл өгч, 2023 оны үйл ажиллагаанд нь амжилт хүслээ.

Хурлын төгсгөлд Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат жилийн ажлынхаа ололт, дутагдлыг дүгнэн, Агаарын цэргийн нэн шинэ түүхийн эхлэл тавигдаж байгаа энэ үед ажлаа улам эрчимжүүлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж, ирэх жилд дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа танилцууллаа.

Цахим шууданд

"ЗАЛУУ ОФИЦЕРУУД БИД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТЭЭРЭЭ МАНЛАЙЛАГЧ НЬ БАЙХ ЁСТОЙ"



Зэвсэгт хүчний Жанжин штабаас 2023 оныг "Залуу офицеруудын манлайллын жил" болгон зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын зарим залуу офицерыг "Миний залуу нас цэргийн хуаранд" сэдвийн хүрээнд ярилцлагад уриалаа. Тэдний нэг нь Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн батарейны захирагч, ахлагч дэслэгч Батнасангийн Сайнтогтох.

Ахлах дэслэгч Б.Сайнтогтох нь Хөвсгөл аймгийн Жаргалант сумынх, эхээс тавуулаа. Айлын бага. Аав Б.Батнасан, ээж Б.Энхсайхан нар нь өдгөө Архангай аймгийн Батцэнгэл суманд мал маллан амьдарч яваа ийм л жирийн нэгэн малчин айлын офицер хүү.

Тэрээр 2015-2019 онд ҮБХИС-ийн ЦНС-ийн Артиллерийн командын офицер мэргэжлээр суралцаж төгсөнөөсөө хойш Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд салаа болон батарейны захирагчаар ажиллаж байна. Энэ цаг үед ҮБХИС-ийн ЦНС-ийн "Ротын захирагч"-ийн дамжаанд суралцаж байгаа, ирэх нэгдүгээр сард төгсөх гэнэ. Мэдээж салаа болон батарейн захирагчаар ажиллаж байгаа энэ хугацаандаа "Залуу хүн бүхний түрүүнд" гэсэн зарчмаар Зэвсэгт хүчний "Марш-тусгай бэлтгэл"-ийн аварга шалгаруулах тэмцээн, Монгол Улсын Төрийн далбааны өдөрт зориулсан цэргийн ёслолын жагсаал болон "Сэлэнгэ" хамтарсан сургуулиас эхлээд Зэвсэгт хүчний уралдаан тэмцээн,



сургалт дадлагад нөхдийнхөө хамтаар цэргүүдтэйгээ оролцож яваа залуу офицер. Тэр бүртээ гаргасан амжилт нь чамгүй их бөгөөд ирэх жилүүдэд түүнээс ч илүү олон медалийн эзэд болж, нэгтгэлийнхээ 100 жилд бэлэг барина гэсэн зорилго өвөртөлжээ. Түүнээс сэдэвтэйгээ уялдуулан "Залуу офицер хүний баримтлах зарчим"-ыг нь сонирхоход "Мөрдэс зүүсэн хэнд ч нэг зарчим байх ёстой. Эх орноо гэсэн сэтгэл, албаа гэсэн итгэл. Тээр нэг жил Хуурай замын цэргийн командлагчаар ажиллаж байсан хошууч генерал Б.Амгаланбаатар манай нэгтгэлийн алба хаагчдад яриа хийхдээ сэтгэлд юм бодогдуулсан онцгой үг хэлсэн. Зэвсэгт хүчин албандаа хайртай хүмүүсийн нуруун дээр л явдаг юм гэж. Албандаа хайртай алба хаагч андашгүй байдаг, тэд сүүлийн үеийн залуус шиг илүү нөхцөл шаардахаас илүү цэрэг дайчид гэсэн ерөнхий утгаар нь харж, ажилладаг, хичээдэг, зүтгэдэг. Би биш Зэвсэгт хүчин гэж харч чаддаг" гэж хэлэхийг сонсоод өөрийгөө илүү их дайчилж ажиллах хүсэл бадарсан гэв.

Ахлах дэслэгч үргэлжлүүлэн "Цэрэг хүн тушаалыг хэлэлцдэггүй, зөвхөн гүйцэтгэдэг" гээд дээд удирдлагынхаа өгсөн үүрэг даалгаврыг боломж гэж хардгаа тодотгов. Залуу офицерын хамт олондоо хүргэх хамгийн эерэг нөлөөлөл нь эрч хүчтэй, ажлаас халшраагүй, зогсолтгүй байх ёстой. Дадлага туршлага дутаж болно, гэхдээ эрч хүч, хүсэл тэмүүлэл нь дутаж болохгүй. Залуу хүний гол имидж өөрөө энэ. Ажлаас зугтсан, аргацаасан, ард нь үлдсэн байж таарахгүй. Хэрэв ийм зан чанарыг өөртөө бий болговол та амьдралдаа ч залуу хойрго болно. Тэгэхээр

зогсолтгүй бөгөөд хичээнгүй байхыг залуу офицер, ахлагч нартаа уриалмаар байна гэв.

Салааны захирагчаар 4 орчим жил ажиллахдаа олон зуун хугацаат цэргийн алба хаагчийг удирдан чиглүүлснээрээ бахархаж явдаг. Одоо цэргүүд нь үргэлж "Салааны захирагч" хэмээн бахдан дуудаж, ажил, амьдралаа хуваалцан, зарим үед заавар зөвлөгөө авах нь ч олон гэнэ.

Түүний ойрын хүсэл мөрөөдөл энхийг сахиулах ажиллагаанд оролцож, англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх гэнэ лээ. Үүнээс өмнө 2023 онд түүхт 100 жилийнхээ ойтой золгох эгнээнээсээ 10 баатар төрүүлсэн Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлдээ цэрэгжлийн спорт тэмцээнээс хэд хэдэн медаль авчрах

төлөвлөгөөтэй яваа ажээ.

Ахмад Д.БОЛОР



Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №35

БА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

БА бол хатуу дэвсгэр үсэг юм. Бүтцийн хувьд нурууны шугам дээр гэдэс зурж, үргэлжлүүлэн нум болгон нуруутай нийлүүлж бичдэг. Үгийн төгсгөлд дэвсгэрлэсэн хэлбэрийг бичихдээ нумыг урагш үргэлжлүүлэн орхиц болгодог. Үгийн төгсгөлийн "БИ" үеийн "И"-гийн нумыг бичихдээ нуруун дээр нь дөрвөлжиндүү хэлбэрээр гаргадаг. ОЦМХ-ний шүргэх "В" гийгүүлэгчийг монгол бичигт энэхүү "БА" үсгээр тэмдэглэдэг.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог БА, БЭ, БИ, БО, БУ, БӨ, БҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:

